



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/108

Мандалговь

Г Гэрээ байгуулах тухай Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/53 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “Хулд сумын сургуулийн дотуур байрны засварын ажил” /БСШУСЯ/2001703008/-ын гүйцэтгэгчээр “Дөл БГМ” ХХК – ийг сонгон 71,419,000 /далан нэгэн сая дөрвөн зуун арван есөн мянга/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Зураг төсвийн дагуу засварын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг “Дөл БГМ” ХХК-ний гүйцэтгэх захирал /Г.Буджав/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, засварын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Н.Эрдэнэ-Очир/, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /Э.Чагнаадорж/, Хулд сумын Засаг дарга /Ч.Зоригтбаатар/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200334